

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ДОТООД АУДИТЫН АЛБА**



ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

**Аудитын нэр: МАНДАЛ СУМЫН “ТОХИЛОГ ХАРАА” ААТҮГ-ЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

Аудитад хамрагдсан жил: 2023-2024

**АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА: СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА**

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: “ТОХИЛОГ ХАРАА” ААТҮГ

АУДИТ ХИЙГДСЭН ОБЪЕКТ: “ТОХИЛОГ ХАРАА” ААТҮГ

АУДИТЫН ТӨРӨЛ: ДОТООД АУДИТ

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА: 2024.09.02-2024.10.18

АУДИТАД ХАМРАГДСАН ХУГАЦАА: 2023-2024

Тайланг бэлтгэсэн:

**Дотоод аудитын нэгжийн
удирдлагын дарга**

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
дэргэдэх Санхүүгийн хяналт,
дотоод аудитын албаны дарга,
СХШУАБ-Т Одсүрэн

Аудитын багийн гишүүн :

Дотоод аудитор, улсын
байцаагч Ц.Уртнасан
urtnasan@sankhuuaudit.se.gov.
mn

Огноо: 2024 оны 10 дугаар
сарын 18 өдөр

Сүхбаатар сумын 2 дугаар баг,
Нутгийн удирдлагын II байр
selenge@sankhuuaudit.se.gov.
mn

1. ТАНИЛЦУУЛГА

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ,

2.1. Аудитын зорилго

2.2. Аудитын цар хүрээ

2.3. Аудитын арга аргачлал, хязгаарлалт

3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

3.1. Засаглалын талаар

3.2. Эрсдэлийн удирдлагын талаар

3.3. Дотоод хяналтын талаар

4. АУДИТЫН ҮР ДҮН

4.1. Илэрсэн асуудлууд

5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. ТАНИЛЦУУЛГА

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10¹, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3² дахь хэсгийг үндэслэн аймгийн Засаг дарга бөгөөд Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2024 оны 06 дүгээр сарын 07-ны өдрийн 04 дүгээр удирдамжийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Мандал сумын "Тохилог хараа" аж ахуйн тооцоот үйлдвэрлэлийн газрын (цаашид "Тохилог хараа" ААТҮГ-гэх) үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудитыг Засгийн газрын 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийг тус тус үндэслэн санхүүгийн хяналт шалгалт, эрх зүйн нийцлийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ба 2023 – 2024 оны эхний хагас жилийн үйл явцыг хамруулан, дахин тооцоолох, тулган шалгах хяналтын горимыг ашиглах, холбогдох ажилтнуудтай ярилцах, дотоод хяналтын орчныг судлах, үнэлэх, ажил гүйлгээг батлах, хянах, бүртгэх, тайлагнах процессын эрсдэлийг үнэлэх, мөрдвөл зохих хууль тогтоомжийн зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн байдлыг бодитоор илэрхийлж тогтоох, зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж байгаа байдлыг шалгуур үзүүлэлтээр тодорхойлж ажиллав.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго:

"Тохилог хараа" ААТҮГ-ын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

"Тохилог хараа" ААТҮГ-ын удирдлага зохион байгуулалтын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг үнэлэх;

Аудитаар тус газрын 2023 - 2024 оны эхний хагас жилийн үйл, ажиллагаа, төсөв, санхүү, өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалтыг хамруулна. Үүнд:

- ☛ *Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг үнэлэх;*
- ☛ *Эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлийн үр нөлөөг тооцох.*
- ☛ *Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, холбогдох хууль тогтоомжууд,*

Засгийн газрын тогтоол шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв

- ✚ байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт.*
- ✚ Өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд бүрэн тусгасан эсэх.*
- ✚ Улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалт, урсгал зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийн үр дүн*
- ✚ Гудамжны гэрэлтүүлгийн өртөг, нийтийн тээврийн зардлын тооцоолол, үр нөлөөтэй байдал*
- ✚ Мал нядалгааны газрын орлогын бүрдүүлэлт, бүртгэл, өр авлагын тооцоо үйлдсэн байдал*
- ✚ ААТҮГ-ын алдагдлыг бууруулахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн*
- ✚ Төрийн аудитын байгууллагаас 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байдал*

Аудитын хамрах хүрээний хязгаарлалт:

“Тохилог хараа” ААТҮГ-ын 2023-2024 оны үйл ажиллагааны хамрах хүрээнд хязгаарлалт тогтоохгүй болно.

2.3 Аудитын арга, аргачлал

Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон улсын стандарт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Монгол улсын сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэн албан тушаалтнаас асуулга тодруулга авах, нотлох зүйлсийг нягтлах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх горимуудыг ашиглав.

2.4. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, журам, дүрэм, зааврыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Төсвийн тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Татварын ерөнхий хууль
- Мандал сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын “Тохилог хараа” ААТҮГ-тай холбоотой тогтоол
- СТОУС, НББОУС болон бусад стандартууд
- “Тохилог хараа” ААТҮГ-ын дүрэм
- Бусад хууль, эрх зүйн актууд

2.5 Аудитын хугацаа, бүрэлдэхүүн

Дотоод аудитыг 2024 оны 09 дугаар сарын 02-ний өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга (Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч) Т.Одсүрэн хянан удирдаж, Дотоод аудитор, улсын байцаагч Ц.Уртнасан гүйцэтгэв.

3. Байгууллагын сайн туршлага

Сум орон нутгийн удирдлагууд болон аж ахуй нэгж байгууллагуудтайгаа хамтран ажилласны үр дүнд 2023 онд орон нутгийн төсвөөс 66,778.6 мянган төгрөгийн хогийн цэгийн хашаа, 85,504.0 мянган төгрөгийн Хэрх тосгоны гэрэлтүүлгийн хөрөнгө оруулалтыг шийдүүлсэн, “Мандал энерго” ОНӨААТҮГ-аас 186,743.8 мянган төгрөгийн Мах бэлтгэх төвийн барилга байгууламжийг балансаар шилжүүлж авсан байна. 2024 онд орон нутгийн төсвөөс 44,700.0 мянган төгрөгийн LUYU-930 трактор ковш /цас түрэгч, цас шүүрдэгч/, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 185,000.0 мянган төгрөгийн гинжит тракторын /хогийн цэг түрэх, булшлах тэгшлэх/ хөрөнгө оруулалтыг шийдүүлсэн. Энэ нь энгийн хог хаягдал болон барилгын хог хаягдлыг ачихад ажилчдын ачаалал багасаж, ажлын бүтээмж нэмэгдэж ажиллах нөхцөл нь сайжирсан байна.

Сангийн сайдын дэмжлэгээр Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны 06 сард Sinotruck Howo маркийн ачааны өөрөө буулгагч автомашин хүлээн авснаар Зил 130 автомашинаар 4 удаа рейс хийхэд 314.9 мянган төгрөгийн зардал гардаг байсныг 1 удаа рейсээр 174.0 мянган төгрөгийн түлш шатахуун хэрэглэдэг болж зардал буурах нөхцөл бий болж байна.

Ажилчдын аюулгүй байдлын үүднээс 10 жолоочийг 2 жилийн хугацаатай жолоочийн хариуцлагын даатгалд хамруулсан байна.

Байгууллагынхаа ажиллагсдынхаа тав тухтай байдлыг хангах үүднээс граш дотор халуун ус барьсан, захиргааны байр, өрөө тасалгаануудыг засварлан тохижилтыг хийж гүйцэтгэж байна.

3.1 Засаглалын талаар

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Засаг даргын захирамжаар 2013 онд “Зүүнхараа хот тохижуулах газар” нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 90 дугаар тогтоолоор “Тохилог хараа” ААТҮГ болон өөрчлөгдсөн байна.

“Тохилог хараа” ААТҮГ-ын даргаар 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрөөс 2024 оны 07 сарын 31-ний өдөр хүртэл Э.Баярхүү, 2024 оны 08 сарын 27-ны өдрөөс Н.Цэрэнтогтох даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдон ажиллаж байна.

Тус байгууллагад төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулаагүй байна.

Байгууллагын дотоод журмаар даргын дэргэд зөвлөх эрхтэй 9 хүний бүрэлдэхүүнтэй даргын зөвлөл байна.

“Тохилог хараа” ААТҮГ-ын эрхэм зорилго: Мандал сумын тохижилт үйлчилгээний цэвэр цэмцгэр байдлыг хангах, иргэдийн тав тухтай орчныг бүрдүүлэхэд оршино.

Дээрх зорилгын хүрээнд дараах үндсэн үйл ажиллагааг эрхэлж байна. Үүнд:

- Хог тээвэр, тохижилт
- Гэрэлтүүлэг
- Мал нядалгаа
- Машин тоног төхөөрөмж түрээсийн орлого /хово, индүү цагийн 150.0 мянган төгрөг/

Сэлэнгэ аймгийн Мандал сум нь 2024 оны 2 улирлын байдлаар 26841 хүн амтай, 7229 айл өрх, 870 аж ахуйн нэгж байгууллага бүртгэлтэй байна.

Тохилог хараа ААТҮГ нь айл өрх, аж ахуй нэгж байгууллагын хог тээвэр, Мандал сумын 53 км зам /суурьшлын төв доторх 26 км зам, олон улсын замтай холбогдсон зам 27 км зам/, 11 км явган хүний замын арчлалт цэвэрлэгээ, Мандал сум, Хэрх, Түнхэл тосгон, Тарни багийн авто зам дагасан 1580 цэгийн гэрэлтүүлгийн ашиглалтын засвар үйлчилгээ, хэвийн үйл ажиллагааг бүрэн хариуцан ажиллаж байна.

Мал нядалгааны газарт 2023 онд 2185 бод, 2222 бог, 2024 оны 8 сар хүртэл 1082 бод, 1162 бог мал гаргасан байна.

“Тохилог хараа” ААТҮГ нь гүйцэтгэх алба, нийтлэг үйлчилгээний алба гэсэн бүтэцтэй ба батлагдсан орон тоо 2023 онд 39, 2024 онд 41 ажилтан албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Эрсдэлийн удирдлагын талаар

Тус газар нь эрсдэлийн удирдлагын бодлого, журам боловсруулаагүй, эрсдэлийн бүртгэл хөтлөөгүй байна. Байгууллагын эрсдэлийн үйл явцыг үнэлэхэд хүлээн зөвшөөрөх эрсдэл, эрсдэлийн мэдээллийг ашиглах зэрэг үнэлэх шалгууруудын түвшин бүрд байгууллагын эрсдэлийн удирдлагыг тодорхойлж үнэлээгүй байна.

Байгууллагын даргын 2024 оны А/09 “Ёс зүйн зөвлөл байгуулах тухай” тушаал гарсан. 2023, 2024 онд ёс зүйн зөрчилтэй холбоотой өргөдөл гомдол ирээгүй байна.

Байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвшлийг тодорхойлоход эрсдэлийн соёл, эрсдэлийн засаглал, эрсдэлийн үйл явц эхлэлийн буюу 2-р түвшинд байна.

Иймд “Тохилог хараа” ААТҮГ-ын даргад байгууллагын эрсдэлийн журмыг боловсруулж батлан, төлөвлөгөө боловсруулан, биелэлтийг цаг тухай бүрд тайлагнан хариу арга хэмжээ авч ажиллахыг зөвлөж байна.

3.3 Дотоод хяналтын системийн талаар

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг Зохион байгуулах нийтлэг журам”, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэм, Хөдөлмөрийн дотоод журамд дотоод хяналтын ажилтантай байна гэж тусгасан ба тус байгууллагын зам талбайн инженер, ХАБЭА Б.Бат-Үүл дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаж байна.

2023 онд дотоод хяналт хийгдээгүй. Байгууллагын даргын 2024 оны А/05 “Дотоод хяналт шалгалтын комисс томилох тухай” тушаалыг үндэслэн 2024 оны 04 сард 1 улирлын ажлын гүйцэтгэлд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Иймд ААТҮГ-ын даргад байгууллагын дотоод хяналтын сул орон тоонд ажилтан томилон ажиллуулах, эс бөгөөс дотоод нөөц бололцоондоо тулгуурлан бусдаар хавсран гүйцэтгүүлэхийг зөвлөж байна.

4. АУДИТЫН ҮР ДҮН

<u>Илэрсэн асуудал 1</u>	Байгууллагын хэмжээнд дотоод хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэсэн боловч эрсдэлийг тооцох, бүртгэх журам боловсруулаагүй байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө дунд
Бодит байдал: Байгууллагын үйл ажиллагаанд учирч болох эрсдэлүүдийг үнэлэх, бүртгэх журам боловсруулаагүй, дотоод хяналт, шалгалтын ажилтны батлагдсан орон тоо байхгүй. Дотоод хяналт шалгалтыг Зам талбайн инженер, ХАБЭА Б.Бат-Үүл хариуцаж гүйцэтгэж байна. 2023 онд дотоод хяналт хийгээгүй. Байгууллагын даргын 2024 оны А/05 тушаалаар 4 сард мах бэлтгэх төвийн ажиллагаа, орлогын байцаагч, нягтлан, нярвын ажилд дотоод хяналт шалгалтыг хийсэн байна. 2024 оны 07 сард машин техникийн бүрэн бүтэн байдал, байгууллагын орчны цэвэрлэгээ, ариутгалд дотоод хяналтыг хийсэн байна. Механикч Ш.Лхагва хог тээврийн 6, тусгай техникийн 7 нийт 13 автомашины техникийн бүрэн бүтэн байдалд сар бүр үзлэг хяналт хийсэн байна. 2024 оны 08 сард Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газар, Хөдөө аж ахуйн газраас хамтарсан шалгалтыг Мах бэлтгэх төвийн үйл ажиллагаанд хийсэн байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Олон улсын мэргэжлийн практикийн стандарт 2120 “Дотоод аудитын үйл ажиллагаа нь эрсдэлийн удирдлагын үйл явцын үр дүнтэй байдлыг үнэлж түүнийг сайжруулахад хувь нэмрээ оруулах ёстой”, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Үндсэн үйл ажиллагааны болон санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байна. Дотоод хяналтын бүтэц, ажиллах журмыг дарга батална”	
Асуудлын үндсэн шалтгаан: Байгууллагын үйл ажиллагаанд учирч болох эрсдэлүүдийг үнэлэх, тогтоох журам байхгүй, боловсруулаагүй байна.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Эрсдэлээ тодорхойлоогүй нөхцөлд байгууллага зорилгодоо хүрэхэд саад бэрхшээл тулгарах Байгууллагын үнэ цэнэ буурна, төсөв санхүүгийн хүндрэл учирч хэвийн үйл ажиллагаа алдагдана.	
Шийдвэр: Байгууллагын засаглалыг сайжруулахад эрсдэлийг бүртгэж үнэлэх, бодлого журмыг боловсруулан баталж хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.	

<u>Илэрсэн асуудал 2</u>	Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг 2023-2024 онд үндэслэлгүй төлөвлөж батлуулснаас байгууллагын үйл ажиллагааны зардал орлогоос 3.3 дахин давсан гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.
---------------------------------	--

Асуудлын ангилал	Нөлөө дунд
Бодит байдал: Мандал сумын ИТХ-ын 94 дүгээр тогтоолоор "Тохилог хараа" ААТҮГ-ын 2023 онд зардлын дээд хэмжээг 919,388.7 мянган төгрөг, сумын ИТХ-ын 2023 оны 111 тогтоолоор татаас санхүүжилтийн орлого болон урсгал зардлыг 30,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна. Гүйцэтгэл 922,388.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 3,377,780.5 мянган төгрөгийн зардал гарган /үүнээс үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 2,493,216.2 мянган төгрөг/, 2,455,567.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан гэж тайлагнасан байна. Нийт орлогын төлөвлөгөө 27,115.6 мянган төгрөгөөр тасарсан нь тоног төхөөрөмжийн түрээсийн орлого тасалдсанаас шалтгаалсан байна. Мандал сумын ИТХ-ын 133 дугаар тогтоолоор "Тохилог хараа" ААТҮГ-ын 2024 онд зардлын дээд хэмжээг 1,221,874.5 мянган төгрөгөөр баталсан байна. Хагас жилийн санхүүгийн тайлангийн гүйцэтгэлээр 1,850,594.5 мянган төгрөгийн зардал гарган /үүнээс үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 1,250,277.9 мянган төгрөг/, 1,341,665.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан гэж тайлагнасан байна. Нийт орлогын төлөвлөгөө 30,764.3 мянган төгрөгөөр тасарсан нь мах бэлтгэх төвийн орлого, тоног төхөөрөмжийн түрээсийн орлого тасалдсанаас шалтгаалсан байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3 дахь заалт "Тохилог хараа" ААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй, Мандал сумын ИТХ-ын 2023 оны 94, 111 тогтоол, 2024 оны 133 тогтоол	
Асуудлын үндсэн шалтгаан: Орлого, зарлагыг үнэн зөв төлөвлөөгүйгээс Мах бэлтгэх төвийн орлогын төлөвлөгөө 2023 онд 31,521.3 мянган төгрөгөөр, 2024 оны 08 сарын байдлаар 19,498.7 мянган төгрөгөөр тасалдсан байна. Түрээсийн орлогын төлөвлөгөө 2024 оны 08 дугаар сарын байдлаар 11,265.6 мянган төгрөгөөр тасалдсан нь Мандал сумын 100 жилийн ойн арга хэмжээнд зориулж гэрэлтүүлэг, зам засварын ажил, сумын бүтээн байгуулалтын ажилд машин техникээ гаргаж ажиллуулснаас шалтгаалсан байна.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг үнэн зөв тодорхойлоогүйгээс ашигт ажиллагаа буурч алдагдлыг хэмжээ нэмэгдэх	
Шийдвэр: НББОУС-16-д заасны дагуу Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох аргыг өөрчилж алдагдлыг бууруулах арга хэмжээг авч ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.	

Илэрсэн асуудал 3	Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж, журмыг мөрдөөгүй 277,540.9 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал: 2023 онд 123,840.9 мянган төгрөг, 2024 онд 123,700.0 мянган төгрөгийн харьцуулалтын аргын босго үнээс давсан түлш шатахууны худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар бус шууд гэрээ байгуулж авсан байна. "Шунхлай петролиум" ХХК, "Тэс петролиум" ХХК, "Сод монгол" ХХК зэрэг компаниудтай шууд худалдан авалт хийсэн байна. 2023 онд гэрэл цахилгааны зардлаас 30,000.0 мянган төгрөгийн худалдан авалтыг харьцуулалтын аргаар тендер зарлалгүй шууд гэрээ байгуулж "АлтынСапа" ХХК-аас гэрэлтүүлгийн толгой худалдан авсан байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төсвийн тухай хуулийн 24.4 "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", ТБОНӨХБАУХА тухай хуулийн 6.1, 8.4, 31 дүгээр зүйлийн 31.1. дэх "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна.", 31.1.1. дэх "нээлттэй", 31.1.2. дахь "харьцуулалт", Засгийн газрын 2021 оны 124 тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа 20 сая төгрөг, ажил 20 сая	

төгрөг, үйлчилгээ 20 сая төгрөг”, “Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа 100 сая төгрөг, ажил 150 сая төгрөг, үйлчилгээ 100 сая төгрөг”,

Асуудлын үндсэн шалтгаан:

Мандал суманд 4 шатахуун түгээх станц байдаг боловч 2022 оны жилийн эцсээр “Шунхлай петролиум” ХХК-д 4,427.5 мянган төгрөг, “Тэс петролиум” ХХК 5,717.5 мянган төгрөгийн өртэй байсныг 2023 оны шатахууны батлагдсан зардлаас шилжүүлсэн. 2023 онд 123,840.9 мянган төгрөгийн шатахууны зардалд тендер зарлаагүй, 2024 онд 123,700.0 мянган төгрөгийн түлш шатахууны тендерийг 2024 оны 6 сард Tender.gov.mn -ээр зарласан боловч өнөөдрийг хүртэл тендер оролцогч материалаа ирүүлээгүй гэх шалтгаанаар “Сод монгол” групп, “Шунхлай петролиум” ХХК-аас түлш шатахууныг шууд худалдан авалт хийсэн хэвээр байна. 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас дээрх зөрчилд зөвлөмж өгсөн. 2024 онд уг алдаа зөрчлийг залруулахгүй, давтан гаргасан байна.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Хууль тогтоомжийг зөрчсөн алдааг давтан гаргасан.

Шийдвэр:

Цаашид худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг мөрдөж зөрчлийг дахин давтан гаргахгүй байх **277,540.9** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Илэрсэн асуудал 4	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын гүйцэтгэл дутуу хийгдсэн, бүрэн дуусаагүй байхад санхүүгийн тайланд бүртгэсэн зэрэг нийт 152,282.6 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.
--------------------------	--

Асуудлын ангилал	Нөлөө их
-------------------------	----------

Бодит байдал:

- 2023 онд Мандал сумын хөрөнгө оруулалтаар 66,778.6 мянган төгрөгийн Хогийн цэгийн хашааг СЭАМСЗДТГ/202309024 дугаартай комиссын актаар хүлээн авч “Тохилог хараа” ААТҮГ-т хүлээлгэн өгснийг санхүүгийн тайлан бүртгэлд тусгасан байна. “Ачлалт төмөр хэлхээ” ХХК-ийн гүйцэтгэсэн энэхүү ажилд дулааны улиралд хийгдэх нүхийг бетон зуурмагаар чигжих, будаг хийх, өргөст торны нэг үе нэмж татах, хашаа тус бүрд 3 үе босоо чиглэлд өргөст тор татах ажлууд үлдсэн боловч одоог хүртэл хийгдээгүй байна.

2023 онд Сумын хөрөнгө оруулалтаар 85,504.0 мянган төгрөгийн Хэрх тосгоны гэрэлтүүлэг суурилуулах /100 ширхэг гудамж талбайн гэрэлтүүлэг/ ажил “Дарханбилгүүн баялаг” ХХК-аар гүйцэтгүүлснийг Сэлэнгэ аймгийн Барилга захиалагч ОНӨААТҮГ, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Мандал сумын дэд бүтцийн мэргэжилтэн, гүйцэтгэгч “Нарсан цамхаг” ХХК нараас төлөөлөл гарч ГЦ-103/2023 дугаартай комисс гарч хүлээн авсан боловч цахилгааны төлбөрийг гүйцэтгэгч компани төлж байна. “Тохилог хараа” ААТҮГ-т уг ажлыг хүлээлгэн өгсөн акт үйлдээгүй, хүлээн аваагүй учир гэрэлтүүлгийн гэмтэл засварыг хийгээгүй байна. “Тохилог хараа” ААТҮГ нь тус байгууллагаас комисс гарч хүлээн аваагүй хөрөнгийг 2023 оны 12 сард санхүүгийн тайланд бүртгэсэн байна.

Сангийн сайдын дэмжлэгээр Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны 06 сард Sinotruck Howo маркийн ачааны өөрөө буулгагч автомашин хүлээн авсан боловч өнөөдрийг хүртэл Нийслэлийн ИТХ-ын тогтоол гараагүй шалтгаанаар улсын дугаар аваагүй, үндсэн хөрөнгөнд бүртгээгүй байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.6 “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг

<p>үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”</p>
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Байгууллагын нягтлан бодох бүртгэлд тавих хяналт сул байна Захиалагч тал болох сумын ЗДТГ-т дутуу хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг бүрэн хийлгэж дуусгах талаар шаардлага тавиагүй, хамтран ажиллаагүй.</p>
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Хөрөнгийг бүрэн дуусгаагүй, хүлээлгэн өгөөгүй байхад тайлант хугацаанд санхүүгийн тайланд бүртгэсэн.</p>
<p>Шийдвэр: Цаашид захиалагч тал болох Мандал сумын ЗДТГ-тай хамтран гүйцэтгэгч компаниудаар дутуу хийгдсэн ажлыг хийлгэх, бүрэн дуусгаж комисс гарган хүлээн авах зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 152,282.6 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>

Илэрсэн асуудал 5	Хандив тусламжаар хийгдсэн хөрөнгө оруулалтыг данс бүртгэлд огт тусгаагүй 125,000.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.
Асуудлын ангилал	Нөлөө их
<p>Бодит байдал: 2021 онд аж ахуй нэгж байгууллага, иргэд, албан хаагчдын хандив дэмжлэгээр байгууллагын хашаанд 15*25 харьцаатай 375 м2 хэмжээтэй, 11 машин багтах дулаанд холбогдсон граш барьсан ба 2023 оны 10 сард албан хаагчдын дэмжлэгээр граш дотроо душ барьсан байна. Нийт өртөг нь 125,000.0 мянган төгрөг болсон уг грашийг байгууллагын баланс бүртгэлд огт тусгаагүй байна.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2. “бүх хөрөнгө, ...”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1. дэх хэсэг “Төрийн өмчид эд хөрөнгийг дараах хэлбэрээр олж авна: 6.1.4: Хандив, тусламж, бэлэглэл, өвлөх журмаар олж авсан эд хөрөнгө”</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бодлогын баримт бичиг болон холбогдох дүрэм журмыг мөрдөж ажиллаагүй. Байгууллагын нягтлан бодох бүртгэлд тавих хяналт сул байна</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Хөрөнгийг тайлант хугацаанд нь бүртгээгүйгээс санхүүгийн тайлан, мэдээ буруу тайлагнах, тухайн хөрөнгийг капиталжуулсан зардлыг үнэлж бүртгэхгүй байх.</p>	
<p>Шийдвэр: Цаашид хандив, тусламжаар хийж гүйцэтгэсэн ажлыг холбогдох байгууллагын зөвшөөрөл, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэх комисс гарган хүлээн авах, хүлээн авсан хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн санхүүгийн тайланд бүртгэх, хөрөнгө хүлээн авахтай холбоотой санхүүгийн анхан шатны баримтад байгууллагын дотоод хяналт шалгалтыг хийж тайлагнах, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 125,000.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>	

Илэрсэн асуудал 6	Мал нядалгааны алба 2023 онд 31,521.3 мянган төгрөгийн, 2024 оны 8 сарын байдлаар 19,498.7 мянган төгрөгийн нийт 51,020.0 мянган төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасалдаж, алдагдалтай ажилласан байна.
Асуудлын ангилал	Нөлөө их
<p>Бодит байдал: Мах бэлтгэх төвийн орлогын төлөвлөгөө 2023 онд 91,677.7 мянган төгрөг, гүйцэтгэл 60,156.4</p>	

мянган төгрөг, 2024 онд орлогын төлөвлөгөө 87,954.9 мянган төгрөг, гүйцэтгэл 45,937.9 мянган төгрөг байна. Орлогын төлөвлөгөө 2023 онд **31,521.3** мянган төгрөгөөр тасалдсан. 2024 оны 8 сарын байдлаар орлогын төлөвлөгөө 58,636.6 мянган төгрөг төвлөрүүлэх ёстойгоос 39,137.9 мянган төгрөгийн орлого орж **19,498.7** мянган төгрөгөөр төлөвлөгөө тасалдсан байна. 2024 оны 8 сарын байдлаар мах бэлтгэлийн төв аж ахуй нэгж, иргэдээс 1,986.7 мянган төгрөгийн авлагатай байна. Мах бэлтгэлийн орлогыг бэлнээр огт авдаггүй, дансанд шууд шилжүүлдэг, нярав сар бүр дансны орлогыг мах бэлтгэлийн төвийн орлогын баримттай тулган өглөг, авлагын тооцоог нь гарган хянаж авсан байна.

Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас 2024 оны 05 дугаар сарын 24 өдөр баталсан 08-00-03/23 дугаартай төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай удирдамжаар 2024 оны 08 сарын 24 өдөр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч Ц.Эрдэнэжав, Мал эмнэлгийн газрын Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Б.Золзаяа нарын бүрэлдэхүүнтэй “Тохилог хараа” ААТҮГ-ын харьяа Мал төхөөрөх цэгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн хүнсний чанар, стандартын чиглэлээр 21, мал эмнэлгийн хяналтын чиглэлээр 15 зөрчил илэрч хуулийн хэрэгжилтийг хангуулах хугацаатай албан шаардлага өгсөн байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах, Мандал сумын ИТХ-аар баталсан “Тохилог хараа” ААТҮГ-ын 2023, 2024 оны мах бэлтгэлийн төвийн орлогын /бусад орлого/ төлөвлөгөө.

Асуудлын үндсэн шалтгаан:

Бодит байдал, тооцоо судалгаанд үндэслэн нийт орлого, зардлыг үнэн зөв төлөвлөөгүй

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Төлөвлөсөн орлого тасалдах, алдагдалтай ажиллах, санхүүгийн төлөвлөгөө биелэхгүй байх. Стандартын шаардлага хангаагүй барилга байгууламж ашигласнаас шалтгаалан үйл ажиллагаа явуулахад мэргэжлийн байгууллага болон иргэдээс санал шүүмжлэл байнга ирэх

Шийдвэр:

Цаашид Мах бэлтгэлийн төвийн алдагдлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, мэргэжлийн байгууллагаас тавигдсан шаардлагыг байгууллагын хэмжээнд биелүүлэхэд анхаарах ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

<u>Илэрсэн асуудал 7</u>	Төрийн аудитын газраас 2023 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар илэрсэн алдаа зөрчлийг бүрэн арилгагүй, 2024 онд зарим алдааг давтан гаргасан байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө дунд
<p>Бодит байдал:</p> <ol style="list-style-type: none"> 2024 онд 81,619.8 мянган төгрөгийн түлш шатахууныг зарцуулахдаа хагас жилийн тайлангаар “Сод монгол” ХХК, “Шунхлай петролиум” ХХК-тай тооцоо нийлсэн акт үйлдээгүйгээс санхүүгийн тайлан дахь өглөгийн дүнг нотлох боломжгүй байна. 2024 оны 08 дугаар сар хүртэл 16 иргэн, аж ахуй нэгж байгууллагаас нийт 14,364.7 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авсан боловч хагас жилийн тайлангаар ихэнх газартай тооцоо нийлсэн акт үйлдээгүй байгаагаас санхүүгийн тайлан дахь өглөгийн дүнг тулган баталгаажуулах боломжгүй байна. 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар Нийгмийн даатгалын болон, татварын тайланд цалин, авлага, өр төлбөрийг 8,711.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан зөрчилд албан шаардлага өгснийг залруулаагүй байна. Дотоод аудитын явцад “Тохилог хараа” ААТҮГ-ын даргын 1/147 албан тоотоор тус байгууллагын 2024 оны 1, 2 дугаар улирлын цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын тайланг засварлах хүсэлт илгээсэн ба 1/148 албан тоотоор Мандал сумын Нийгмийн даатгалын тасагт 2023 оны 05, 10, 11 сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг 	

залруулах хүсэлт илгээсэн байна.

3. Орлого, зарлагыг үнэн зөв төлөвлөөгүйгээс Мах бэлтгэх төвийн орлогын төлөвлөгөө 2023 онд 31,521.3 мянган төгрөгөөр, 2024 оны 08 сарын байдлаар 19,498.7 мянган төгрөгөөр тасалдсан байна. Түрээсийн орлогын төлөвлөгөө 2024 оны 08 дугаар сарын байдлаар 11,265.6 мянган төгрөгөөр тасалдсан нь Мандал сумын 100 жилийн ойн арга хэмжээнд зориулж гэрэлтүүлэг, зам засварын ажил, сумын бүтээн байгуулалтын ажилд машин техникээ гаргаж ажиллуулснаас шалтгаалсан байна.
4. Кассын орлого буюу орлогын байцаагчийн хог үүсгэврийн төлбөрийн орлогыг тухай бүр хянасан байна.
5. Төрийн мэдээлэл солилцооны хур системд тухайн байгууллагын эзэмшилд 2 газар бүртгэлтэй байгаа боловч санхүүгийн тайланд 6 газар бүртгэгдэж тайлагнагдсан бөгөөд тухайн газруудыг өөрийн эзэмшилд шилжүүлээгүй зөрчил илэрсэн. Дотоод аудитын явцад "Тохилог хараа" ААТҮГ-ын даргын 2024 оны 1/142 албан тоотоор газрын гэрчилгээгүй газартаа гэрчилгээ гаргуулах, 1/143 албан тоотоор эзэмшил нь өөр нэр дээр бүртгэлтэй байгаа газар эзэмших гэрчилгээг тус байгууллагын нэр дээр шилжүүлэх хүсэлт хүргүүлсэн. Үүний дагуу 2024 оны 09 сарын 04-ний өдөр Мандал сумын газрын асуудал эрхэлсэн албан тушаалтнаас хариу мэдэгдэл ирсэн байна. 1 газарт цахим гэрчилгээ үүсгэх боломжтой, 2 газарт 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган шийдвэрлүүлэх боломжтой, 1 газарт Мандал сумын Засаг даргын 2005 оны захирамжаар сумын ЗДТГ-н нэр дээр цахим гэрчилгээтэй, 1 газарт аймгийн ИТХ-аар хамаарах тогтоол гаргуулан эзэмшигчийн нэр өөрчлүүлэх боломжтой талаар мэдэгдсэн байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах", 20.2.6-д "...үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах..." гэсэн заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар Маягт заавар батлах тухай тушаалын хэвсрэлт: "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт"
2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2 дахь "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ.", 20.2.5: "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"
3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэсэн заалт болон Мандал сумын ИТХ-ын баталсан "Тохилог хараа" ААТҮГ-ын 2023, 2024 оны санхүүгийн орлого, зарлагын төлөвлөгөө"

Асуудлын үндсэн шалтгаан:

Байгууллагын удирдлага дотоод хяналтаар уг алдаа, зөрчлийг залруулах арга хэмжээ аваагүй, хэрэгжилтэд хяналт тавихгүй байх

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Өмнөх онд гаргасан алдаа зөрчлийг давтан гаргах

Илэрсэн алдаа зөрчлийн хэмжээгээр сум орон нутгийн алдааны нэгтгэлд нөлөөлөх

Шийдвэр:

Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, алдаа зөрчлөө залруулах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

<u>Илэрсэн асуудал 8</u>	Ашиглах боломжгүй болсон, элэгдлээ бүрэн нөхсөн нийт 170,325.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган сумын ИТХ, хөлбөгдөх дээд шатны байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө бага
Бодит байдал: Газар дээр нь очиж тулган баталгаажуулахад 2024 оны хагас жилийн тайлангаар ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө нөхсөн 170,325.1 мянган төгрөгийн 12 төрлийн үндсэн хөрөнгөөс цаашид ашиглах боломжтой хөрөнгийг үнэлж бүртгээгүй байна. Үүнээс 40,955.1 мянган төгрөгийн хөрөнгө хэвийн ашиглагдаж, 129,120.0 мянган төгрөгийн хөрөнгө эвдэрсэн, 250.0 мянган төгрөгийн хөрөнгө ашиглагдахгүй болсон байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 7.1 дэх "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9.1 дэх "Аймаг, нийслэлд төрийн өмчийн төлөөлөгч ажиллана."	
Асуудлын үндсэн шалтгаан: Үндсэн хөрөнгийн тооллогыг зохих журмын дагуу хийж гүйцэтгээгүйн улмаас ашиглах боломжгүй хөрөнгүүдийн тооцоо судалгааг гаргаж орон нутгийн өмчийн газарт хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Дээрх хөрөнгө нь байгууллагын үндсэн хөрөнгийн дансны дүнг нэмэгдүүлж, бодит үнэ цэнийг бууруулж байна.	
Шийдвэр: Цаашид үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглах боломжгүй, эдийн засгийн хувьд үр өгөөжгүй хөрөнгийн тооцоо судалгааг гарган, орон нутгийн өмчийн газарт актлуулах саналыг хүргүүлэх зөвлөмж өгөв.	

<u>Илэрсэн асуудал 9</u>	2024 онд зарцуулсан нийт 81,619.8 мянган төгрөгийн түлш шатахууны зарцуулалтын тайланг гаргахдаа анхан шатны баримтыг аргачлалын дагуу үнэн зөв хөтлөөгүй байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө дунд
Бодит байдал: "Тохилог хараа" ААТҮГ нь нийт 13 автомашинтай ба үүнээс 6 машин хог тээвэрт, 7 машин тусгай техникийн зөөх, зөөвөрлөх, замын индүү, өргөгч кран гэмт мэт машинууд байна. Эдгээр 13 машинаас 50 ковш машин /түрэгч трактор/, Лууц 930 трактор, гинжит трактор, зам шүүрдэгч, замын индүү, автогридэр, кран автомашинууд мото цагийн заалттай. Бусад 7 автомашин нь спидометрийн заалтаар ажилладаг. Газар дээр нь ирж шалгахад спидометрийн заалтаар ажилладаг автомашинууд бүгд спидометр нь ажиллахгүй байна. Газрын даргын 2021 оны 38 дугаар тушаалаар 1 рейст 10 литр А92 шатахуун зарцуулахаар үнэ тарифыг тогтоосон ба хог тээврийг сарын хуваарь батлан хог тээвэрт явж байна. Хог тээврийн хуваарь гаргасан боловч замналын км-ийн хэмжээ тодорхой бус, өдөрт явсан рейсийн тооны бүртгэл дутуу байна. 2024 онд 81,619.8 мянган төгрөгийн түлш шатахууны зарцуулахдаа Сангийн сайдын 2017 оны 347 дугаар Маягт заавар батлах тухай тушаалын хавсралт "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маяг"-ыг мөрдөөгүй байна.	

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "хөлбөгдөх олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар Маягт заавар батлах тухай тушаалын хавсралт "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт"

Асуудлын үндсэн шалтгаан:

Анхан шатны баримтыг үнэн зөв хөтлөөгүй, хог тээврийн хуваарьт газруудад маршрутаар км -ийг тооцож гаргаагүй, рейсийн бүртгэлийг тухай бүрд бүртгээгүй, автомашинуудад GPS суулгаагүй

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Бараа материалын тайлан мэдээ буруу гарах, баримт дутах эрсдэлтэй.

Шийдвэр:

Цаашид түлш шатахууны зарцуулалтын тайланг гаргахдаа анхан шатны баримтыг аргачлалын дагуу үнэн зөв хөтлөх, хог тээврийн хуваарьт газруудад маршрутаар км тооцож, рейсийн бүртгэлийг хөтөлж байх талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Мандал сумын "Тохилог хараа" ААТҮГ-ын 2023-2024 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн дотоод аудитаар тус байгууллагад "Сайжруулах шаардлагатай" гэсэн дүгнэлтийг өгч байна.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Сайжруулах шаардлагатай	Засаглал эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь "эхлэлийн буюу 2-р түвшин"-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 21-79% нь "нөлөө ихтэй" гэж үзсэн.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ДОТООД АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ

Ц.УРТНАСАН

ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Т.ОДСҮРЭН

ТАНИЛЦСАН:


МАНДАЛ СУМЫН "ТОХИЛОГ ХАРАА" ААТҮГ-ЫН

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Н.ЦЭРЭНТОГТОХ

НЯГТЛАН БОДОГЧ

Ж.МӨНХЗАЯА



Илэрсэн зөрчлийн нэгтгэл:

№	Зөрчлийн товч утга	Нийт Тоо	Нийт Дүн	Шийдвэрлэлт мөнгөн дүн (мянган төгрөгөөр)					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Эрсдэлийг тооцох журам боловсруулаагүй.	1						1	
2	Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлийн үр нөлөөг тооцохдоо өмнөх оны гүйцэтгэлд суурилж бус зардал нэмэх зорилгоор орлогын төлөвлөгөөг баталсан.	1						1	
3	Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж, журмыг мөрдөөгүй шууд худалдан авалт хийсэн	1	277,540.9			1	277,540.9		
4	Улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын гүйцэтгэл дутуу хийгдсэн, бүрэн дуусаагүй байхад санхүүгийн тайланд бүртгэсэн, хандив тусламжаар хийгдсэн хөрөнгө оруулалтыг данс бүртгэлд огт тусгаагүй	2	277,282.6			2	277,282.6		
5	Мал нядалгааны алба 2023, 2024 онд орлогын төлөвлөгөө тасалдаж, алдагдалтай ажилласан	1	51,020.0					1	51,020.0
6	Төрийн аудитын газраас 2023 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар илэрсэн алдаа зөрчлийг бүрэн арилгаагүй, 2024 онд зарим алдааг давтан гаргасан	1						1	
7	Ашиглах боломжгүй болсон, элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган сумын ИТХ, холбогдох дээд байгууллагад	1	170,325.1					1	170,325.1

	хүргүүлж шийдвэрлүүлээгүй								
8	2024 онд зарцуулсан түлш шатахууны тайланг бүрэн, зөв бүрдүүлээгүй	1	81,619.8					1	81,619.8
	Нийт дүн	9	857,788.4			3	554,823.5	6	302,964.9